



**ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН ШИНЭ ҮЕ СУРГУУЛИЙН
СУРГАЛТЫГ ДЭМЖИХ ХИЧЭЭЛЭЭС ГАДУУРХ ҮЙЛ
АЖИЛЛАГААНЫ ЖУРАМ**

Боловсруулсан: 2021 оны 08 сар

Дахин хянах: 2023 оны 08 сар

Хэрэгжих хүчинтэй хугацаа: 2 жил

Шинэ Үе сургууль

2021 он

ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН ШИНЭ ҮЕ СУРГУУЛИЙН СУРГАЛТЫГ ДЭМЖИХ ХИЧЭЭЛЭЭС ГАДУУРХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЖУРАМ

НЭГ. ҮНДЭСЛЭЛ

Бага дунд боловсролын тухай хуулийн 18 дугаар зүйл дэх “Хичээлээс гадуурх сургалтын ажил нь суралцагчдын танхимд эзэмшсэн мэдлэг, чадварыг бататгах, баяжуулах, тэдний авьяас, сонирхлыг гүнзгийрүүлэн хөгжүүлэхэд чиглэнэ”, Ерөнхий боловсролын сургалт, үйл ажиллагаанд тогтвортой хөгжлийн боловсролын үзэл санааг тусган, хэрэгжүүлэх үндсэн шаардлагад “Ерөнхий боловсролын сургалт, үйл ажиллагаа, сургалтын хөтөлбөрт ”Байгаль орчин, эдийн засаг, нийгэм соёлын уялдаа холбоог цогц байдлаар агуулгын болон арга зүйн шийдлийг хийх, суралцагчдад хандлага, үнэт зүйлс, хэрэглээний чадварыг төлөвшүүлэх ажлыг эрчимжүүлэх шаардлагатай,” Ерөнхий боловсролын сургуулийн үлгэрчилсэн дүрмийн “Сургалтын ажил нь хичээл, хичээлээс гадуурх сургалт, хүүхдийн хөгжил, төлөвшлийг хангах тэдгээртэй холбоотой бусад ажлаас бүрдэнэ.”, Сургууль хичээлээс гадуурх сургалт хүмүүжлийн ажлын төлөвлөгөөтэй ажиллана” эдгээр эрх зүйн баримт бичгүүд үндэслэл болно.

Үндэслэлд баримталсан хууль тогтоомжууд:

1. Боловсролын тухай хууль
2. Бага дунд боловсролын тухай хууль
3. Сургалтын хөтөлбөр
4. Сургалтын төлөвлөгөө
5. Хичээлээс гадуурх сургалтын ажлын үлгэрчилсэн хөтөлбөр /БСШУ-НЫ Сайдын 2020.12.22 өдрийн А/99/
6. IB хөтөлбөрийн Нийгэмд тустай үйл хичээлийн гарын авлага /CAS/

ХОЁР. ЗОРИЛГО

Суралцагч нь олон улсад хүлээн зөвшөөрөгдөхүйц XXI зууны цогц чадамжуудыг эзэмшихэд дэмжлэг үзүүлэхэд оршино.

ГУРАВ. ЗОРИЛТ

ЗОРИЛТ 1. Гэр бүлийн хүрээнд олгох хүмүүжил, төлөвшлийг дэмжих

- 1.1. Хүмүүжлийн үйл ажиллагаанд гэр бүлийн оролцоог нэмэгдүүлэх
- 1.2. Хүүхэд хүмүүжүүлэх гэр бүлийн уламжлалт соёл, ёс суртахууны үнэт зүйлд тулгуурлан сургалтын болон сургалтыг дэмжих үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх /эцэг эхийн зөвлөлүүд нийгмийн ажилтнууд/

ЗОРИЛТ 2. Эрүүл, аюулгүй амьдрах арга ухаанд сургах, төлөвлөх, зохион байгуулах, бүтээлч байдлыг нь дэмжих

2.1. Амьдралын аюулгүй байдлыг эрхэмлэдэг, хорт зуршлаас урьдчилан сэргийлэх соёлыг төлөвшүүлэх үйл ажиллагааг тогтмолжуулах

2.2. Хүүхдийг идэвхтэй, эрүүл амьдралын хэв маягт сургах, эрүүл хоол хүнс хэрэглэхийн ач холбогдлыг таниулахад чиглэсэн үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх /Эмч, нийгмийн ажилтнууд, эрүүл мэндийн багш/

2.3. Сурагчдын төлөвлөх чадварыг хөгжүүлэхэд чиглэсэн үйл ажиллагааг төлөвлөгөөндөө оруулах тэднийг бие даан гүйцэтгэх арга барилд сургах, гарах үр дүнгээ тооцдог эрсдлийг тооцоолох даван гарах арга барилд сургах /Клубын үйл ажиллагаа явуулж буй багш нар, анги удирдсан багш нар эцэг эхийн зөвлөл/

ЗОРИЛТ 3. Болзошгүй эрсдлүүд, гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх үр чадвар эзэмшүүлэх

3.1. Хүүхдийг шударга ёс, шударга байдал, нинжин сэтгэлийг эрхэмлэдэг, эцэг эх, багш, ахмад үе, үе тэнгийнхэн болон бусад хүмүүсийг хүндэтгэх үзлийг төлөвшүүлэх; /Нийгмийн ажилтнууд, хамтарсан баг, нийгмийн ухааны багш нар, иргэний боловсролын багш нар, монгол хэл, бичиг/

3.2. Сургуулийн хүүхэд хамгааллын хөтөлбөрт тусгасан сургалт, нөлөөлийн ажил, орчинг бүрдүүлэх/ Хүүхэд хамгааллын хөтөлбөрийн зургаадугаар заалтуудыг хэрэгжүүлэх/

ЗОРИЛТ 4. Авьяас билэг, оюуны чадварыг хөгжүүлэх

4.1. Хүүхдийн оюун ухааныг хөгжүүлэхэд чиглэсэн шинжлэх ухаан танин мэдэхүйн, зохион бүтээх чиглэлийн үйл ажиллагааг дэмжин хэрэгжүүлэх /БУЗАН, МАТ мэдээлэл зүй, БАЗАН, технологи/

4.2. Уламжлалт өв, соёл, биет бус өвийг өвлүүлэх, түгээн дэлгэрүүлэх, сурталчлах /Хөгжим, дүрслэх урлаг технологи, нийгмийн ухааны багш нар, монгол хэл бичиг/

4.3. Орчин үеийн цаашилбал дэлхийн урлаг, уран сайхныг бүтээлийг сурталчлах зорилготой хүүхдийн урлаг, соёлын үйл ажиллагааг нэмэгдүүлэх, түгээн дэлгэрүүлэх, дэмжин хөгжүүлэх /Хөгжим, дүрслэх урлаг технологи, монгол хэл, бичиг/

4.4. Олон нийтийг хамарсан спортын арга хэмжээнд оролцох, эерэг жишээг сурталчлах, дэлгэрүүлэх /тамир, хөгжим/

4.5. Сурагчдын сонирхол хэрэгцээн дээр тулгуурласан сонирхлын клубүүдийг удирдан зохион байгуулах /Ангигүй багш нарын холбоо/

4.6. Сурагчдын давуу талыг илрүүлэх, байгааг нь илүү чадваржуулахад чиглэсэн үйл ажиллагааг хамтран төлөвлөх зохион байгуулах /CAS удирдагч багш нар, Анги удирдсан багш нар, эцэг эхчүүд/

4.7. Сурагчдыг өөрийн чаддаг зүйлсийг нь илүү хөгжүүлэхээс илүүтэйгээр би юу хийж чаддаггүй вэ? түүнийгээ хийж турших оролдлого хийж байсан талаар тэдэнд бодуулах, оролдуулах, гэхдээ заавал оролдсон болгон амжилттай байх албагүй талаар тэдэнд ухаж ойлгуулах, шинэ зүйлсээс айхгүй байх чадварыг суулгах ажлыг клубын гишүүддээ өгөх /CAS удирдагч багш, клуб дугуйлан хичээллүүлэх багш нар/

ЗОРИЛТ 5. Мэдээллийн технологийн зохистой хэрэглээг дэмжих

5.1. Интернетийн болон бусад орчинд хүүхдийн эрүүл мэнд, өсөлт хөгжилтөд сөргөөр нөлөөлж болохуйц мэдээллээс хамгаалах төрөл бүрийн аргуудыг сурталчлах сургалт зохион байгуулах /Мэдээллийн технологийн багш нар/

5.2. Мэдээллийн технологийн эрүүл мэндэд сөрөг нөлөө үзүүлж болохуйц хор уршгийн талаар сургалт сурталчилгаа явуулах /Эмч, Эрүүл мэндийн багш/

5.3. Цахим хэрэглээний эерэг жишээг сурталчлах /Мэдээллийн технологийн багш нар/

ЗОРИЛТ 6. Суралцагчдын нийгэм, олон нийтийн үйл ажиллагааг дэмжих, нийгэмд тустай үйлчилгээ хийж сургах

6.1. Хүүхдийн эрх ашиг сонирхолтой холбоотой асуудлаар шийдвэр гаргахад чиглэгдсэн ажлыг эрчимжүүлэх /нийгмийн ажилтнууд/

6.2. Сурагчдыг үзвэр үйлчилгээ үзэх соёлыг дээшлүүлэх чиглэлээр үйл ажиллагаа зохион байгуулах сурталчлах /хөгжим, анги удирдсан багш, нийгмийн ажилтнууд/

6.3. Хүүхдийн эрх зүйн мэдлэг, соёлыг дээшлүүлэх, тэдний эрх ашиг сонирхолтой холбоотой асуудлуудаар шийдвэр гаргахад чиглэсэн ажлыг эрчимжүүлэх /Нийгмийн ухааны багш нар, эрүүл мэндийн багш/

6.4. Сурагчдыг нийгэмд тустай үйл ажиллагаанд бүтээлчээр оролцох чадвар, сэтгэлгээг суулгах, тэдэнд дэмжлэг үзүүлэх /нийгмийн ажилтан, CAS удирдагч багш нар, клуб дугуйлан секцийн удирдагч багш нар/

ЗОРИЛТ 7. Эх оронч болон хөдөлмөрийн хүмүүжлийг дэмжих

7.1. Суралцагчдыг нийгэмд тустай үйл ажиллагаанд бүтээлчээр оролцоход дэмжлэг үзүүлэх /Анги удирдсан багш нар, эцэг эхийн зөвлөл, Нийгмийн ажилтнууд/

7.2. Эцэг эх, багш нар, суралцагчдын санаачилгаар хичээлээс гадуурх үйл ажиллагааг зохион байгуулах /Анги удирдсан багш нар, эцэг эхийн зөвлөл, Нийгмийн ажилтнууд/

7.3. Ажил мэргэжлийн чиг баримжаа олгох үйл ажиллагааг хэрэгжүүлэх

ЗОРИЛТ 8. Байгаль, экологийн хүмүүжлийг төлөвшүүлэх

8.1. Хүүхдэд байгаль дэлхий эх, орон газар нутгаа хайрлах хандлага төлөвшүүлэх ажлыг дэмжих, хэрэгжүүлэх /байгалийн ухаан, нийгмийн ухаан, бага ангийн багш нар, Монгол хэл, бичиг/

8.2. Байгаль, экологийн чиглэлээр олон талт үйл ажиллагааг зохион байгуулах, хэрэгжүүлэх /БУЗАН/

8.3. Тогтвортой хөгжлийн боловсролыг олгоход чиглэсэн сургалт, үйл ажиллагааг эрчимжүүлэх, сурталчлах /БУЗАН, НУЗАН/

ДӨРӨВ. ХИЧЭЭЛЭЭС ГАДУУРХ СУРГАЛТААР ХӨГЖҮҮЛЭХ ЧАДВАР

4.1. Хичээлээс гадуурх үйл ажиллагаагаар XXI зууны дараах цогц чадамжуудыг эзэмшүүлнэ.

4.1.1. Бүтээлч сэтгэлгээний чадвар

- Бүтээлчээр сэтгэх
- Хувиараа бизнес эрхлэх
- Зохион бүтээх
- Эргэцүүлэх
- Тунгаан бодох
- Асуудал шийдвэрлэх
- Шийдвэр гаргах

4.1.2. Нийгэмшихүйн чадвар

- Зохион байгуулах
- Багаар ажиллах
- Хамтарч ажиллах
- Нийтэч байх
- Өөрийгөө бусдын оронд тавьдаг байх
- Бусдыг өрөвдөх чадвар

4.1.3. Харилцаа хамтын ажиллагааны чадвар

- Харилцааны чадвар
- Хувийн сахилга баттай байх

- Сэтгэл хөдлөлөө хаянах
- Хүлээцтэй байх
- Хариуцлагатай байх
- Ёс зүйтэй байх
- Бие дааж суралцах
- Дасан зохицох чалвартай байх
- Шаргуу байх
- Өөрийгөө удирдах

4.1.4. Мэдээллийн технологийн хэрэглээний чадвар

- Мэдээлэл харилцааны технологиор дамжуулан мэдээлэл олж авах чадвар
- Мэдээлэлд дүн шинжилгээ хийх чадвар
- Мэдээллийн технологи, мэдээллийг ёс зүйтэй хэрэглэх чадвар

4.2. Сургалт зохион байгуулах үйл ажиллагаа

- Ангийн үйл ажиллагаа
- Секц, дугуйлангийн үйл ажиллагаа
- Сургуулийн дотоод үйл ажиллагаа
- Суралцагчдын зөвлөлийн үйл ажиллагаа
- Хөгжүүлэх чадвар

Ангийн үйл ажиллагаа

- Ангийн зорилго, зохион байгуулалт хамт олны уур амьсгал, эв нэгдлийг бэхжүүлэхтэй холбоотой үйл ажиллагаа
- Хувь суралцагчийн нэр хүнд, эрүүл мэнд, аюулгүй байдалтай холбоотой үйл ажиллагаа

Секц, дугуйлангийн үйл ажиллагаа

- Суралцах арга барилыг сайжруулахтай холбоотой үйл ажиллагаа /Сэтгэхүй хөгжүүлэх клубүүд/
- Өөрийн авьяас чадварыг нээж хөгжүүлэхтэй холбоотой үйл ажиллагаа /ардын урлаг, тайз дэлгэц, бүжиг, найрал дуу, үндэсний болон орчин үеийн хөгжим, дүрслэх урлаг, дизайн, техникийн загвар, гар урлал, загвар зохион бүтээх, шатар даам, хөнгөн атлетик, спорт тоглоом, мэтгэлцээний клуб, гадаад хэлний клуб гэх мэт/

Сургуулийн дотоод үйл ажиллагаа

- Тэмдэглэлт болон уламжлалт үйл ажиллагаа
- Амжилтаа тайлагнах
- Сургуулийн өдөр тутмын дэг, соёл, эрүүл аюулгүй байдалтай холбоотой үйл ажиллагаа
- Ажил хөдөлмөр нийгмийн сайн сайхны төлөө хийх үйл ажиллагаа

- Ангийн цэцэгжүүлэлт /ургамал хамгаалал/
- Сургуулийн цайны газрын хариуцлагын зохион байгуулалт
- Сургуулийн номын санчдад туслах
- Аялал зугаалга, эх оронтойгоо танилцах тойрон аялал

Суралцагчдын удирдах зөвлөлийн үйл ажиллагаа

- Сургууль, орон нутгийн хөгжлийг дэмжих чиглэлийн дагуу хувь нэмрээ оруулах үйл ажиллагаа

4.3. Орчин, хэрэглэгдэхүүн

Танхимын орчинд:

- Багаар, бүлгээр, уулзалт ярилцлага хэлэлцүүлэг зохион байгуулах
- Урлаг, спорт, хурлын заал, анги танхим дахь үйл ажиллагаа, илтгэл тавих

Танхимын бус орчинд:

- Нийслэлийн төрийн болон төрийн бус байгууллага, олон улсын байгууллага, үйлдвэрүүдийн үйл ажиллагаатай танилцах аялал хийх
- Сургууль, эцэг эхийн хамтын үйл ажиллагаанд тулгуурласан үйл ажиллагаа
- Төсөлт ажил, судалгаа хийх
- Бүтээлч санал санаачлага бүхий сайн үйлсийн аян өрнүүлэх
- Зайны сургалт зохион байгуулах
- Орон нутгийн мэргэжлийн байгууллагын байр, танхим, олон нийтийн газар, байгаль орчныг түшиглэн явуулна.

ТАВ. ХИЧЭЭЛЭЭС ГАДУУРХ СУРГАЛТЫН АЖЛЫГ ҮНЭЛЭХ

- Сэтгэл ханамжийн судалгаа, ярилцлагыг багш, эцэг эх, суралцагчдаас авах ба мөн өөрийн үнэлгээний хуудсаар үнэлнэ.
- Суралцагчдын авьяасаа хөгжүүлж, харилцан суралцаж буй байдлыг үзэсгэлэн, тайлан тоглолт, бүтээлийн сангаар үнэлнэ.

Хичээлээс гадуурх үйл ажиллагааг АУБ нар, эцэг эхийн зөвлөлтэйгөө хамтран зохион байгуулахдаа CAS-ийн доорх гурван төрлийн үйл ажиллагааны сонголтуудаас дор хаяж нэг төрлийн үйл ажиллагаа, түүн дотроос 3 ажлыг сонгон төлөвлөгөөндөө оруулж зохион байгуулна.

Бүтээлч үйл ажиллагаа (Creativity)

Энэ хэсэгт ямар нэгэн шинэ санал санаачилгыг хөгжүүлэх эсвэл сайжруулах ажил хийнэ. Жишээ нь:

- Харааны бэрхшээлтэй хүмүүст зориулан аудио ном бүтээх, кино зохиол бэлдэх
- Хэрэгцээтэй байгаа хүмүүст нь зориулж гадаад хэл заах, эсвэл технологи ашиглан гадаад хэл сурах гарын авлага бичих, сайжруулах, эсвэл вебсайт эсвэл бусад төрлийн мэдээллийн хэрэгслүүдээр дамжуулан суралцаж буй гадаад хэл, соёлын талаар бусдын анхаарал татахуйц үйл ажиллагаа зохион байгуулах
- Өндөр настны асрамжийн газар байгаа хүмүүсийн амьдралын түүхийг сонсож, тэдний ярьсан зүйлсийг бичлэг болгон гэр бүлд нь дурсгах, нийгэмд тулгамдаж буй асуудалд туслах зорилгоор нийгэмлэг байгуулах эсвэл олон нийтийн цэцэрлэгт хүрээлэнд сайн дураар туслах
- Бага болон дунд ангийн суралцагчдад зориулж одон орныг судлах клуб ажиллуулах
- Хөгжим тоглодог хүүхэд ая зохиох, зураг зурдаг хүүхэд фото зургийн үзэсгэлэн гаргах, баримал хийх гэх мэт үйл ажиллагаа явуулах
- Жүжигт тоглох дуртай хүүхэд жүжиг найруулах, зохиох эсвэл олон нийтийн театрын клубд нэгдэх
- Сургууль дээр ямар нэг клуб ажиллуулах
- Хоолны дамжаанд суралцах
- Вебсайт хөгжүүлэх
- Өрхийн сарын орлогын зарцуулалтыг хянах сорилт зохион байгуулах
- Цуврал хөрөг зургууд зурах, сийлбэр хийх гэх мэт.

Өөрийн бие махбодийг хөгжүүлэх ажил (Activity)

- Эрүүл амьдралын хэв маягт зориулан дасгал хөдөлгөөн хийх, бие мах бодийг хөгжүүлэх сургалт зохион байгуулах
- Ганцаарчилсан болон багийн спортоор хичээллэх
- “Сургуульдаа явганаар ирэх алхалтын клуб” байгуулах
- Аеробикийн дасгал хийх эсвэл булчин хөгжүүлэх дасгал хийх
- Бүжгээр хичээллэх
- Ууланд авирах

- Бусад суралцагчидтай хамтран спортын дугуйлан хичээллүүлэх, хичээллэх /гүйлтийн клуб, теннисний клуб гэх мэт/
- Явган аялал хийх
- Цанаар гулгаж сурах гэх мэт

Сайн дурын ажил (Service)

- Бодит хэрэгцээ шаардлагад тулгуурласан тусламжийн үйл ажиллагаа зохиож хүмүүстэй хамтран ажиллаж, харилцан туслалцах
- Байгалийн тэнцвэрт байдлыг хадгалахад туслах үйл ажиллагаа зохион байгуулах
- Математикийн хичээлээр сурлагын хоцрогдолтой байгаа хүүхдүүдэд хичээл заах эсвэл математик бодит байдал дээр өдөр тутмын амьдралд ямар байр суурь эзэлдгийг мэдрүүлэхийн тулд математикийн хичээлээр Scavenger hunt уралдаан зохион байгуулах
- Тоглолтод бэлтгэж бүжиг, жүжгийн хичээл заах, уран зургийн эсвэл фото зургийн үзэсгэлэнд оролцох, зохион байгуулах.
- Малын хашаанд ажиллах
- Цэцэрлэгт хүрээлэнд ажиллах, мод тарих, жимс тарих, арчлах
- Ашгийн бус байгууллагын вебсайтыг шинэчлэн өгөх
- Хэл заахын тулд бодит зурагтай ном бүтээх
- Ялгаварлан гадуурхлалтын эсрэг жүжиг тоглох
- Олон нийтийн газарт хог хаях явдлыг бууруулах зорилгоор үр дүнтэй арга хэмжээ авч хэрэгжүүлэх
- Сургуулийн орчинд сургалт явуулах гэх мэт.

CAS-ийн үйл ажиллагаанд суралцагч оролцсоноор дараах үр дүнд хүрнэ. Үүнд:

- Өөрийнхөө давуу талууд ба хөгжүүлэх шаардлагатай талуудыг танин мэдэх
- Үйл ажиллагааны явцад тулгарах сорилтуудыг даван туулснаар шинэ чадварууд эзэмших ба хөгжүүлэх
- CAS-ийн үйл ажиллагааг хэрхэн төлөвлөх, зохион байгуулахыг харуулах
- CAS-ийн үйл ажиллагаандаа тууштай оролцож байгаагаа харуулах
- Бусадтай хамтран ажиллах чадвар, түүний ач холбогдлыг ойлгож мэдэх
- Дэлхий нийтэд ач холбогдол бүхий асуудлуудад оролцоогоо харуулах
- Сонгосон сонголт, хийсэн үйлдээ ёс зүйг баримтлах

**“ШИНЭ ҮЕ” СУРГУУЛИЙН КЛУБ, ДУГУЙЛАН ХИЧЭЭЛЛҮҮЛЭХ БАГШИЙН
БӨГЛӨХ ХЭСЭГ**

1. Клуб, дугуйлан, секцийн нэр:
2. Удирдагч багшийн нэр:
3. Долоо хоногт хичээллэх цаг:
4. Хичээллэх өдрүүд:
5. Таны явуулж буй клуб, дугуйлан, секцэд нэг суралцагч ойролцоогоор хэдий хугацаанд хамрагдах шаардлагатай вэ? /Жишээ нь, цаасан урлалын дугуйланд 1 улирал, зургийн дугуйланд 1 жил гэх мэт/
.....

Клуб дугуйлангийн зорилго /1-2 өгүүлбэрт багтаан бичих/

6. Танай Клуб, дугуйлан, секцийн үйл ажиллагаагаар XXI зууны дараах цогц чадамжуудаас алийг нь эзэмшүүлэх эсэхийг зөвлөнө үү?
7. Сургалт зохион байгуулах үйл ажиллагаа /Өөрийн дугуйлангийн онцлогоос шалтгаалан хэдийг ч сонгож болно./
 - A. Ангийн үйл ажиллагаа
 - B. Секц, дугуйлангийн үйл ажиллагаа
 - C. Сургуулийн үйл ажиллагаа
 - D. Суралцагчдын зөвлөлийн үйл ажиллагаа
 - E. Хөгжүүлэх чадвар

Гол хийх үйл ажиллагааг үргэлжилсэн өгүүлбэрээр доорх хүснэгтэд товч бичнэ үү?

8. Орчин нөхцөл
 - A. Анги танхим
 - B. Заал
 - C. Туршлагын болон задгай талбай
 - D. Лаборатори

9. Хэрэглэгдэхүүний жагсаалт, хэрэглэгдэх материалуудын жагсаалт

.....
.....
.....
.....
.....
.....
.....
.....

10. Таны удирдаж буй клуб, дугуйлан, секцийн үр дүнг хэрхэн үнэлэхээ бичнэ үү?

.....
.....
.....

**“ШИНЭ ҮЕ” СУРГУУЛИЙН КЛУБ, ДУГУЙЛАН, СЕКЦ-Д ХАМРАГДАХ СУРАГЧДЫН
БӨГЛӨХ ХЭСЭГ**

№	Асуумж	Хариулах хэсэг
1	Таны овог нэр	
2	Анги, бүлэг	
3	Сонгосон дугуйлан, секц, клуб	
4	Сонгох болсон шалтгаан	
5	ХГҮА-ны журамтай танилцсан эсэх	
6	Бусад	

Сүхбаатар дүүрэг, 1-р хороо, ЮНЕСКО гудамж 12
Улаанбаатар хот, Монгол улс

Шинэ Үе сургууль
2021 он